

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар

Үр дүн	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтод түвшин	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хариуцах байгууллага	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				2025				
ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ЗАСАГЛАЛ								
ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ИЛ ТОД БАЙДАЛ								
4.2.1.1. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, хуулиар хориглосноос бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно	Нээлттэй, ил тод болгосон мэдээлэл	хувь	80	85	Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуульд заасан мэдээллийн дундаж хувиар тооцсон	Нийт төрийн байгууллагууд	Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийн ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоон, үнэлгээ хийх журам” мөн 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn сайтад 2025 оны I, II, III улиралд тус бүр 5 бүлгийн 87 талбарт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нээлттэй мэдээллийг хуулийн хугацаанд эхний хагас жилийн байдлаар 3 удаа байршуулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны www.shilen.gov.mn сайтад нийтлэгддэг “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ”-ээр 2025 оны I улиралд 98%, II улиралд 97%, III улиралд 98%-ийн тус бүр үнэлэгдсэн.	98%
ЦАХИМ ЗАСАГЛАЛ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ								
4.3.1.5. төрийн албаны хүний	Төрийн албан	хувь	95.4	96	Хөтөлбөр-ийн хэрэгжилт-ийг	Төрийн байгуул-	1.Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 16	100%

<p>нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, сургаж, хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулна.</p>	<p>хаагчийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт</p>				<p>өссөн дүнгээр тооцно</p>	<p>лагууд Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд</p>	<p>арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган, байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. 2025 онд дараах сургалтыг зохион байгуулж, мөн дээд газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна. Үүнд: 1.1.Гадагш чиглэсэн 11 удаагийн сургалтаар 343 төрийн байгууллагын албан хаагч, аж ахуй нэгжийн төлөөлөл оролцсон. ➤ Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангуулах 4 удаагийн сургалтаар 157 байгууллагын удирдах ажилтан, нягтлан бодогч, дотоод хяналт ажилтан, мэдээлэл оруулагч нар ➤ Сайн туршлага хуваалцсан /манлайлал/ 7 удаагийн сургалтаар 186 төрийн албан хаагч 1.2.Албан хаагчдыг мэргэшүүлэх 54 удаагийн сургалтад давхардсан тоогоор 327 албан хаагч хамрагдсан. ➤ Дээд газраас зохион байгуулсан 24 удаагийн сургалтад давхардсан тоогоор 56 албан хаагч ➤ Дотооддоо буюу ажлын байранд зохион байгуулсан 26 удаагийн сургалтад давхардсан тоогоор 261 албан хаагч ➤ 4 удаагийн Зөвлөгөөн, форумд давхардсан тоогоор 10 албан хаагч 2.Байгууллагын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2025 онд 3 зорилт, 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнд: Онцлох ажлаас дурдвал:</p>
--	--	--	--	--	-----------------------------	---	---

						<ul style="list-style-type: none"> ➤ Орхон аймгийн Улаан загалмайн хорооны “Ивээн тэтгэгч” гишүүнээр хамтран ажилладаг. 2025 оны хамтын ажиллагааны хүрээнд 1 албан хаагчийн гэр бүлийн 1 хүнийг “Нүдний болор солиулах” хагалгаа, эмчилгээнд хамруулсан. Хагалгаа, эмчилгээний зардлыг Улаан загалмайн нийгэмлэгээс бүрэн шийдвэрлэсэн. ➤ 2025 оны 3-р сард Улаанбаатар хотын “Таван богд Нура” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, эрт илрүүлэг 11 албан хаагч 10,780.0 мянган төгрөгөөр хамруулсан. ➤ Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар Монголын уламжлалт “Цагаан сарын баяр”, “Ахмадын баяр”-ыг тохиолдуулан 4 ахмад настанд нийт 800.0 мянган төгрөгийн тэтгэмж олголоо. ➤ Албан хаагчдын хүүхдүүдийн дугуйлан, секц, хөгжлийн хөтөлбөрт хамрагддаг судалгааг гаргаж, 1 албан хаагчийн 1 хүүхэд буюу нийт 11 хүүхдэд тус бүр 100.0 мянган төгрөг, нийт 1,100.0 мянган төгрөгийн секц, дугуйлангийн төлбөр, 1 хүүхдэд “Таеквандогийн Олон улсын тэмцээн”-д оролцоход нь 800.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж, “Түшиг Эн Жи Би” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан 1,842.0 мянган төгрөгийн зардлыг шийдвэрлэн 12 хүүхдийг “Генетик тест”-ийн оношилгоонд хамруулсан. ➤ Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр нийт 25,030.7 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил
--	--	--	--	--	--	--

							худалдан авч албан хаагчдын өрөө тасалгааны тохижилт хийсэн.	
4.3.1.6. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулж, хариуцлагыг дээшлүүлнэ.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж зохион байгуулсан арга хэмжээ-ний тоо	тоо	60	65	Төрийн албан хаагчийн Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж зохион байгуулсан арга хэмжээний тоог өссөн дүнгээр тооцсон	Төрийн байгууллагууд Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд	<p>Байгууллагын даргын 2024 оны А/30 дугаартай тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган боловсруулж, байгууллагын даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар 100% ханган ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Шинээр томилогдсон 2 албан хаагчид “Төрийн албаны ёс зүйн тухай хууль”, Ёс зүйн дүрэм, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн. ➢ 2025 оны 10 дугаар сарын 30 өдрөөр төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс гомдол ирээгүй болно. ➢ Албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг байгууллагын Ёс зүйн дэд хороо “Насан туршийн суралцахуйн төв”, Эрүүл мэндийн газар”, “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар” зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. 6 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 63 албан хаагч хамрагдсан. ➢ “Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба” фэйсбүүк 	100%

							<p>хуудас болон албан хаагчдын дундын групп-т Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Байгууллагын стандарт, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор 35 удаагийн байршуулж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хамт олны дунд ёс зүй, харилцаа хандлагын талаар нөлөөллийн томоохон ажлын нэг болох байгууллагын бүх албан хаагчдын дунд “Илтгэл”-ийн уралдаан зохион байгуулсан. ➤ Сар бүр албан хаагчдыг идэвхжүүлэх арга хэмжээг “Удирдамж”-аар баталгаажуулан хэрэгжүүлэлтийг хангаж ажилласан. 	
БИЕЛЭЛТИЙН ХУВЬ								99%

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР